

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
ЗӨВЛӨМЖ**

2018 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

№ *02*

Мөрөн сум

**ИХ-УУЛ, ЭРДЭНЭБУЛГАН, ЧАНДМАНЬ-ӨНДӨР, ТАРИАЛАН,
ЦАГААН-ҮҮР СУМДЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ**

**ГХУСАЗСЗөвлөлийн ажлыг
хэрхэн төлөвлөх талаар**

Хөвсгөл аймгийн прокурорын газрын 4 дүгээр улиралын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зарим сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлыг хамтарсан удирдамжийн дагуу шалгахад ажлын төлөвлөлт, гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авсан эсэх, хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчилах ажил зохион байгуулж байгаа эсэх нь тодорхойгүй, дээрх ажлуудыг хийж гүйцэтгэсэн гэх боловч ажлын эмх цэгц, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж байгаа нь хангалтгүй, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар бичсэн прокурорын мэдэгдэлийн хүрээнд тодорхой арга хэмжээ авч, хариуг хугацаанд нь ирүүлээгүй зэрэг зөрчил дутагдал илэрч байна.

Иймд шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалыг арилгуулах, удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авхуулах зорилгоор зөвлөмж хүргүүлж байна. Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн тухайн жилд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил, улиралаар төлөвлөн тухай бүр биелэлтийг нь тооцон ажиллах. Тухайлбал: жилийн төлөвлөгөөнд ямар ажилыг 1, 2, 3, 4 дүгээр улиралд, эхний болон сүүлийн хагас жилд хийх талаар тодорхой тусгах. Дээрх төлөвлөгөөнөөс улбаалан улиралын төлөвлөгөөг тусад нь гаргаж тухайн улиралд хийж гүйцэтгэх ажилыг тус улиралын хэд хэдэн сард хийхээ төлөвлөн биелэлтийг тооцож байх.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүдийг багт хуваах, жил болон улиралын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтан /багийн гишүүд/ -үүдийг тодорхой зааж өгч тухай бүр биелэлт тооцох, хэрэв хийж гүйцэтгээгүй бол шалтгаан нөхцлийг судлан арга хэмжээ авч, дараа улиралд хийж гүйцэтгэх төлөвлөгөөнд тусгах.

3. Тухайн орон нутгийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан дүн шинжилгээ хийж, ажилаа төлөвлөх. Тухайн орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт

хэргээс өндөр хувь эзэлж байгаа нэгээс хоёр хэргийг сонгон авч тухайн жилдээ дээрх төрлийн гэмт хэргийг бууруулах жил болгон зарлаж тодорхой үр дүнд хүрэх.

4. Иргэд болон төрийн албан хаагч, ерөнхий боловсролын сургуулын сурагч нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчилах ажлыг тогтмол зохион байгуулах.

5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж байгаа бусад орон нутгын үйл ажиллагаатай танилцан ажлын туршлага солилцох.

6. Гэмт хэргийн шалтгаан нэхцэлийг арилгах талаар прокурорын болон бусад эрх бүхий албан тушаалтны мэдэгдэл, зөвлөмжийг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан түүний дагуу тодорхой арга хэмжээ авч биелэлтийг нь тооцон хариуг нь хугацаанд хүргүүлэж хэвших.

Зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилна уу.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР